



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 8/05

Улаанбаатар хот

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан  
хариу арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өндөртөлгой хотхоны хойд жигүүрийн халаалт, хэрэглээний халуун усны шугамд 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 17.00 цагийн үед гэмтэл гарч тус инженерийн шугамаас халаалт дулаанаар хангагддаг 44 дүгээр цэцэрлэг, Дотоод аудитын алба, орон сууцны 1, 2 дугаар байрны 1-4 дүгээр орцны 130 орчим айл өрхийн халаалт дулаан, хэрэглээний халуун ус тасалдан хөлдөх нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулсугай.

2.Гарсан гэмтлийг богино хугацаанд нь чанар үр дүнтэй шуурхай зохион байгуулж, албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж, илүү цагаар ажилласан нэмэгдэл болон холбогдох зардлыг хууль, журмын дагуу олгож ажиллахыг Илч-Орд ОНӨААТҮГ (Д.Гантулга)-т, үүссэн нөхцөл байдалтай уялдуулан дүүргийн онцгой комиссын шуурхай Ажлын хэсгийн гишүүдийн бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (Хурандаа Б.Цогбадрах)-т тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг дүүргийн менежер (Г.Дагвадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД